



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 1/285  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БАЯНХОНГОР СУМЫН БАЯН-ОЙТ  
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.АЮУРЗАНА ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд баталгаажуулах аудит хийж, аудитын тайлан дүгнэлт, албан шаардлагыг хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Хавсралт... хуудастай.

ДАРГА, ТЭРҮҮЛЭХ  
АУДИТОР  В.МӨНХБАТ



006425030295





## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2025/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сар 10

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК

Захирал Г.Саранчимэг

Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Аудитор: О.Мандах

Утас: 89010203

Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асууда	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Албан шаардлага .....	16
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



「 БАЯНХОНГОР СУМЫН БАЯН-ОЙТ  
ЦОГЦОЛБОРТ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.АЮУРЗАНА ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/38  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「 **Өөрчлөлтгүй дүгнэлт** 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд 1,873,260.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,722,459.4 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 2,292.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, нийт 218,083.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020243

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.2 хувьтай тайлагнасныг 91 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>185,806,319.59</u></b>	<b><u>314,495,275.03</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	69,575,145.43	218,083,761.70
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	69,575,145.43	218,083,761.70
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	69,575,145.43	218,083,761.70
31211	Төрийн сангийн харилцах	69,575,145.43	218,083,761.70
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	116,231,174.16	96,411,513.33
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	8,549,865.40	8,549,865.40
35110	Тусгай зориулалттай материал	8,549,865.40	8,549,865.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	107,681,308.76	87,861,647.93
35410	Бичиг хэргийн материал	2,309,500.00	4,224,500.00
35420	Аж ахуйн материал	46,766,676.13	27,520,346.00
35450	Барилгын засварын материал	12,753,000.00	12,686,000.00
35460	Хүнсний материал	855,100.01	305,900.00
35470	Бусад хангамжийн материал	44,997,032.62	43,124,901.93
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,057,043,910.94</u></b>	<b><u>2,149,506,971.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,057,043,910.94	2,149,506,971.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,057,043,910.94	2,149,506,971.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,057,055,573.00	2,057,055,573.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-167,481,863.09	-209,221,969.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	170,372,738.00	383,562,746.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56,544,600.88	-122,956,946.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,049,634.50	68,299,634.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,954,611.14	-40,779,107.27
39217	Ном	13,547,040.55	13,547,040.55
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,242,850,230.53</u></b>	<b><u>2,464,002,246.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>83,540,700.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	83,540,700.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	83,540,700.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	83,540,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	83,540,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,242,850,230.53</u></b>	<b><u>2,380,461,546.03</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,242,850,230.53	2,380,461,546.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,225,483.90	52,225,483.90
51101	Өмч: - төрийн	52,225,483.90	52,225,483.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,068,359,761.63	2,205,971,077.13
51210	Өмнөх үеийн үр дүн	2,068,359,761.63	2,068,359,761.63
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	137,611,315.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,264,985.00	122,264,985.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,242,850,230.53</u></b>	<b><u>2,464,002,246.03</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,332,673,161.00</b>	<b>1,951,329,228.69</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,848,761.00</b>	<b>79,042,628.69</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	22,848,761.00	79,042,628.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,960,000.00	245,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,750,000.00	245,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,309,824,400.00</b>	<b>1,872,286,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,107,755,700.00	1,659,781,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,107,755,700.00	1,659,781,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	202,068,700.00	212,504,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	202,068,700.00	212,504,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,377,054,737.34</b>	<b>1,813,717,913.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,377,054,737.34</b>	<b>1,813,717,913.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,208,828,604.41	1,653,044,815.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	817,318,592.56	1,086,493,363.50
210101	Үндсэн цалин	563,471,984.69	731,819,863.99
210102	Нэмэгдэл	192,698,864.87	288,418,399.51
210104	Урамшуулал	61,147,743.00	66,255,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	101,984,440.71	136,864,329.32
210201	Тэтгэврийн даатгал	69,508,171.32	94,187,198.48
210202	Тэтгэмжийн даатгал	8,174,128.27	10,861,597.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,539,302.54	5,590,873.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,612,991.19	5,244,931.37
210205	Эрүүл мэндийн даатгал	16,149,847.39	20,979,727.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	157,822,817.07	193,622,028.55
210301	Гэрэл, цахилгаан	9,032,339.07	10,205,748.55
210302	Түлш, халаалт	140,687,626.00	175,934,784.00
210303	Цэвэр, бохир ус	8,102,852.00	7,481,496.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,749,000.00	57,051,681.51
210401	Бичиг хэрэг	12,377,500.00	14,776,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,371,500.00	4,264,500.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	37,966,181.51
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,445,155.00	14,247,700.00
210604	Урсгал засвар	16,445,155.00	14,247,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,784,956.85	8,062,511.72
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,784,956.85	8,062,511.72

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	92,723,640.22	156,703,201.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,147,050.00	32,726,253.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	584,700.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,991,890.22	123,976,947.94
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	168,226,132.93	160,673,097.46
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	157,033,800.00	158,380,676.01
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	129,490,560.00	144,617,776.01
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,543,240.00	13,762,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	11,192,332.93	2,292,421.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,192,332.93	2,292,421.45
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-44,381,576.34</b>	<b>137,611,315.50</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-44,381,576.34</b>	<b>137,611,315.50</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,313,784,400.00</b>	<b>1,872,531,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,960,000.00</b>	<b>245,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,960,000.00	245,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,960,000.00	245,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,750,000.00	245,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,309,824,400.00</b>	<b>1,872,286,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,107,755,700.00	1,659,781,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,107,755,700.00	1,659,781,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	202,068,700.00	212,504,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	202,068,700.00	212,504,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,335,281,372.67</b>	<b>1,669,030,683.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,335,281,372.67</b>	<b>1,669,030,683.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,166,220,139.74</b>	<b>1,508,906,786.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	817,088,665.82	1,086,792,432.95
210101	Үндсэн цалин	553,381,194.63	725,767,093.96
210102	Нэмэгдэл	202,809,728.19	291,193,304.99
210104	Урамшуулал	60,897,743.00	69,832,034.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	102,308,600.00	136,565,259.87
210201	Тэтгэврийн даатгал	69,570,100.00	90,081,360.80
210202	Тэтгэмжийн даатгал	8,184,400.00	11,120,999.73



**Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	6,547,800.00	6,060,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,636,500.00	6,060,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,369,800.00	23,241,899.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	157,822,817.07	193,622,028.55
210301	Гэрэл, цахилгаан	9,032,339.07	10,205,748.55
210302	Түлш, халаалт	140,687,626.00	175,934,784.00
210303	Цэвэр, бохир ус	8,102,852.00	7,481,496.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,053,550.00	16,590,350.00
210604	Урсгал засвар	33,053,550.00	16,590,350.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,064,956.85	20,552,690.72
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,064,956.85	20,552,690.72
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	48,881,550.00	54,784,024.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,283,850.00	42,089,724.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,597,700.00	12,694,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>169,061,232.93</b>	<b>160,123,897.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	157,868,900.00	157,831,476.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	130,325,660.00	144,068,576.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,543,240.00	13,762,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	11,192,332.93	2,292,421.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,192,332.93	2,292,421.45
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>-21,496,972.67</u></b>	<b><u>203,500,916.27</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>36,335,700.00</b>	<b>54,992,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>36,335,700.00</b>	<b>54,992,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	36,335,700.00	54,992,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,335,700.00	54,992,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-36,335,700.00</u></b>	<b><u>-54,992,300.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-57,832,672.67	148,508,616.27
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	127,407,818.10	69,575,145.43
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	69,575,145.43	218,083,761.70



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,771,797.23	-2,771,797.23
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	122,264,985.00	2,068,359,761.63	2,242,850,230.53
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	122,264,985.00	2,068,359,761.63	2,242,850,230.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	122,264,985.00	2,068,359,761.63	2,242,850,230.53
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	137,611,315.50	137,611,315.50
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	122,264,985.00	2,205,971,077.13	2,380,461,546.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,729,243,000.00	1,511,518,183.73	217,724,816.27	87.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,729,243,000.00	1,511,518,183.73	217,724,816.27	87.4%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,554,821,400.00	1,353,686,707.73	201,134,692.27	87.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,264,595,000.00	1,086,792,432.95	177,802,567.05	85.9%
210101	Үндсэн цалин	867,626,600.00	725,767,093.96	141,859,506.04	83.6%
210102	Нэмэгдэл	343,022,000.00	291,193,304.99	51,828,695.01	84.9%
210104	Урамшуулал	53,946,400.00	69,832,034.00	-15,885,634.00	129.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,074,400.00	136,565,259.87	21,509,140.13	86.4%
210201	Тэтгэврийн даатгал	107,490,600.00	90,081,360.80	17,409,239.20	83.8%
210202	Тэтгэмжийн даатгал	12,645,900.00	11,120,999.73	1,524,900.27	87.9%



**Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	6,323,000.00	6,060,500.00	262,500.00	95.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	6,323,000.00	6,060,500.00	262,500.00	95.8%
210205	Эрүүл мэндийн даатгал	25,291,900.00	23,241,899.34	2,050,000.66	91.9%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>34,169,400.00</b>	<b>34,162,690.72</b>	<b>6,709.28</b>	<b>100.0%</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,169,400.00	34,162,690.72	6,709.28	100.0%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>97982600.00</b>	<b>96166324.19</b>	<b>1,816,275.81</b>	<b>98.1%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,288,300.00	83,472,024.19	1,816,275.81	97.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,694,300.00	12,694,300.00	0.00	100.0%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>174421600.00</b>	<b>157831476.00</b>	<b>16,590,124.00</b>	<b>90.5%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>174,421,600.00</b>	<b>157,831,476.00</b>	<b>16,590,124.00</b>	<b>90.5%</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	160,658,700.00	144,068,576.00	16,590,124.00	89.7%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,762,900.00	13,762,900.00	0.00	100.0%
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,659,781,800.00</b>	<b>1,659,781,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,659,781,800.00	1,659,781,800.00	0.00	100.0%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,000.00	245,000.00	0.00	100.0%
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>69,575,145.43</b>	<b>-69,575,145.43</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>218,083,761.70</b>	<b>-218,083,761.70</b>	
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>45</b>	<b>45</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа



Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Баянхонгор сумын Баян-Ойт сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/31 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба гэсэн бүтэц зохион байгуулалттай 45 орон тоотой, 612 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай “ 25 дугаар тогтоолын хавсралт” Боловсролын байгууллагын үйл ажиллагааны олон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай” 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, БНА-2025/133/НА-СТА-ТШЗ

нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,115.2 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	69,575.1	218,083.7	148,508.6
Авлага	0	0	0.00
Бараа материал	116,231.2	96,411.5	-19,819.7
Үндсэн хөрөнгө	2,306,024.9	2,522,464.9	216,440.0
Хуримтлагдсан элэгдэл	-248,981.1	-372,958.0	-123,976.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,242,850.2</b>	<b>2,464,002.2</b>	22,115.2
Өр төлбөр	0.00	83,540.7	83,540.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн емч/	<b>2,242,850.2</b>	<b>2,380,461.5</b>	137,611.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,242,850.2</b>	<b>2,464,002.2</b>	22,115.2

Эх сурвалж: Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын Баян-Ойт сургуулийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 69,575.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 218,083.7 мянган төгрөгийн өмнөх оноос 148,508.6 мянган төгрөгөөр гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотойгоор хүүхдийн тооноос хамаарч төсөв батлагдсан ба гүйцэтгэлээр зарцуулагдсан төсвөөс хэмнэлт үүссэнээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 194,906.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Мөн 890.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 177,605.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж "Эргэлтийн хөрөнгө актлаж данснаас хасах тухай" захирлын 2024 оны 12 дугаар сарн 26-ны өдрийн А/76 дугаар тушаалаар 38,011.2 мянган төгрөгийн бараа материал актлаж бараа материалын үлдэгдэл 19,819.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 138,533.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 77,907.0 мянган төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн дансанд үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэн 216,440.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тайлант онд цахим ангийн тоног төхөөрөмж худалдан авснаас 83,540.7 мянган төгрөгийг өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 137,611.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,380,461.5 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 137,611.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,464,002.2 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,192,271.0 мянга, орон нутгаас авах санхүүжилтийг 203,404.8 мянган төгрөг нийт санхүүжилт 1,395,675.8 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой улсын төсөвт тодотгол хийж санхүүжилтийг 1,659,781.8 мянган төгрөгөөр батлаж 467,510.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн орон нутгаас авах санхүүжилт үнэ тарифын өөрчлөлттэй уялдаж 9,100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,659,781.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 69,575.1 мянга, үйл ажиллагааны орлогоос 245.0 мянга, орон нутгийн төсвөөс 212,504.8 мянган төгрөг нийт 1,942,106.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 1,724,023.0 мянган төгрөгийг зарцуулж 218,083.7 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 212,504.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 98.9 хувь буюу 210,212.4 мянган төгрөгийг зарцуулж 2,292.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэл т
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,178.4	3,178.4	0.0	100.0%
2	80233 Хүүхэд хамгаалал	3,381.6	3,324.8	56,8	98.3%
3	80312 Сургалт семинар	2,241.8	2,175.0	66,8	97,0%
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,173.6	3,017.0	156.6	95.0%
5	81801 Үдийн цай хөтөлбөр	160,658.7	144,068.6	16,590.1	89.6%
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	38,342.3	38,342.3	0.0	100%
7	81823 Боловсролын байгууллагын багш	9,520.7	9,528.0	- 7,3	99.9%
8	81834 Боловсролын стандарт, сургалтын	1,418,903.4	1,232,947.3	185,956.1	89.5%
9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	80,298.9	65,410.2	14,888.7	81.4%
10	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр	9,543.6	9,540.5	3.1	99.9%



Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

11	81844 Гүнгэгийрүүлсэн болон төрөлж	245.0	245.0	0.0	100.00 %
12	80217 Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,327.3	2,327.3	0.0	100.00 %
13	80 Нийтлэг үйлчилгээ	212,504.8	210,212.4	2,292.4	98.9%
	2023 оны харицахын үлдэгдэлээс			69,575.1	
	ДҮН	1,941,747.8	1,723,664.1	218,083.7	88.7%

Эх сурвалж:2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О.Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, Баянхонгор аймгийн газрын дарга, тэргүүлэх аудитор Б. Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Л.Аюурзана, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Амаржаргал нар зурж, нярваар Б.Даваасүрэн нар ажиллажээ.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг оны батлагдсан төсөв 1,967,382.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,673.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,755.3 мянган төгрөгөөр тогтоосон.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,853,238.1 мянган төгрөгийн 21 гүйлгээ, зарлагын 339,882.1 мянган төгрөгийн 30 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаан Д оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	5	5	5	0	
2	Хагас жил	0	0	0	0	
3	Улирал бүр	0	0	0	0	
4	Сар бүр	2	24	24	0	
5	Тухай бүр	7	57	57	0	
	Нийт	14	187	183	0	

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### 4.5 Худалдан авах ажиллагааны талаар

Тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороог захирлын 2024 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн А/04 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, үдийн хоолны 142,060.5 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар 2024 оны 1 дугаар сарын 29-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ний өдрийг хүртэл худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д тендерийн бичиг баримтыг тус тус байршуулсан байна.

Үдийн хоолны материал нийлүүлэх БХАБХССЦЦ/20240102001 дугаартай тендерийг 4 багц болгон зарласан байна

Үдийн хоолны материал нийлүүлэх /багц-3/-д Софтвишн ХХК шалгарч 20,700.0 мянга, /багц-1/-д Цагаан дэнжийн хишиг ХХК шалгарч 45,125.0 мянган төгрөгөөр нийт 65,825.0 мянган төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл байгуулан ажилласан байна.

Багц-2 гурил, гурилан бүтээгдэхүүн , багц-4 Хүнсний ногоо жимс, жимсгэнэ нийлүүлэх тендерийг 2024 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 26-ны өдөр хүртэлх БНА-2025/133/НА-СТА-ТШЗ



хугацаанд дахин зарлаж Далай ээж ХХК шалгаран /багц-2/-д 21,012.0 мянга, /багц-4/-д 31,575.4 мянга нийт 52,587.4 мянган төгрөгийг 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулан ажилласан байна. Худалдан авах гэрээний үнийн дүнг мөрдөн ажиллаж гэрээ дүгнэн ажилласан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянташаагийн эх ХХК гүйцэтгэж зөрчилгүй ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 5.1 Албан шаардлага

Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09 -ны өдрийн Б/42 тоот тушаалаар сургуулийн захиралд балансын урамшууллыг нэг сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 (Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах), 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2024.07.09 өдрийн Б/42 тоот тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1., 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалттай нийцэхгүй байна	1	1,544.0			1	1,544.0		
Нийт дүн	1	1,544.0			1	1,544.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 129/14210513/БНА-2025/133/Монгол  
НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсрол Шинжлэх ухааны яамны 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 2/2772 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалаар төсвийн шууд захирагчид балансын урамшуулал нэг сарын цалинтай тэнцэх 1,544,000 (Нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6,4,1 төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах мөн 16,5.5-батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040257

1.Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох , зөрчлийг арилган биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Баян-ойт цогцолбор сургуулийн захирал Л.Аюурзана, нягтлан бодогч Ж.Амаржаргал нарт даалгав<sup>2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ, АУДИТОР: Г.САРАНЧИМЭГ



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно